



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 10 дугаар сарын 07 өдөр

Дугаар А.212

Улаанбаатар хот

Нэгдсэн эмнэлэг байгуулах тухай

Нэг. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1998 оны А/361 тоот тушаал, Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, дүүргийн нэгдээс тавьж буй хүсэлтийг үндэслэн нийслэлд 1999 онд ажиллах эмнэлгийн орны тоонд багтаан Баянгол дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн дэргэд 50 ортой нэгдсэн эмнэлгийг 1999 оны 10 дугаар сарын 12-ноос эхлэн нээж ажиллуулахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Е.Тэрбиш/-т болон дүүргийн Засаг дарга /С.Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

Хоёр. Баянгол дүүргийн иргэдийн хэвтэн эмчлүүлдэг Клиникийн нэгдсэн 3 дугаар эмнэлгийн дотор, мэдрэлийн тасгаас 50 орыг хасч Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлд шилжүүлж, эмчилгээ үйлчилгээний ажилд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Е.Тэрбиш/-т даалгасугай.

Гурав. Нэгдсэн эмнэлэг нээж ажиллуулахтай холбогдуулан даатгуулагчдын эмчилгээний ор хоногийн хувьсах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх гэрээ байгуулан ажиллахыг Нийслэлийн Нийгмийн даатгалын газар /Ч.Сумаахүү/-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

[Signature]
М.ЭНХБОЛД